

ЗАСГИЙН ГАЗРЫН 2022 ОНЫ 340 ДҮГЭЭР ТОГТООЛЫН
ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ АЖЛЫН ХЭСГИЙН ЯВЦЫН ТАЙЛАН

2023 оны 5 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар
хот

Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах арга хэмжээний тухай” 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс “Хөдөө аж ахуйн бирж” ТӨХХК-ийн 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 312 дугаарт албан тоотор явуулсан саналынхаа хүрээнд Гүйцэтгэх захирлын 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн А/28 дугаар тушаалаар хэрэгжилтийг ханган боломжийг судлах, гүйцэтгэх ажлын хэсэг нь дараах ажлуудыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

1. Биржийн арилжаанд оролцогчдыг сурган мэргэшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн судалгаа хийхэд сургалт явуулах боломжтой Монголын Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, Брокеруудын нэгдсэн холбоо зэрэг байгууллагууд байх тул дээрх байгууллагуудын удирдлагуудтай уулзалт хийсэн.
2. **Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцогчдийг мэргэшүүлэх сургалтын чиг үүргийг** “Хөдөө аж ахуйн бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч мэргэшсэн брокеруудын нэгдсэн холбоо”-нд шилжүүлэхээр 2023 оны 5 дугаар сарын 02-ны өдөр тус холбоотой “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулсан. Чиг үүргийг хэрэгжүүлэх, гүйцэтгүүлэх үүднээс Санхүүгийн зохицуулах хороо, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эд бэлтгэн нийлүүлэгч брокеруудын нэгдсэн холбоо, “Хөдөө аж ахуйн бирж” ХХК хамтран биржийн арилжааны зах зээл сонирхогч, оролцогчдод арилжаанд оролцоход шаардлагатай мэдлэг олгох, мэргэжлийн зуучлалын үйлчилгээ үзүүлэх боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшүүлэх зорилготой “Брокерын эрх олгох” сургалтыг 2023 оны 5 дугаар сарын 10-12-ны хооронд зохион байгуулсан ба 25 оролцогч хамрагдлаа.
3. **Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд оролцогч хоршоог чадавхжуулах сургалтын чиг үүргийг** “Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо”-нд шилжүүлэхээр 2023 оны 5 дугаар сарын 09-ний өдөр тус холбоотой “Хамтран ажиллах санамж бичиг” байгуулсан.
4. **Стандартын шаардлага хангасан агуулах, тээврийн байгууллага итгэмжлэл олгох**, сурган мэргэшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжийн судалгаа хийхэд агуулах, тээврийн байгууллага, лабораторийн эрх олгодог аж ахуйн нэгж байхгүй байна. Мөн Үндэсний итгэмжлэлийн төвөөс “Лаборатори болон тээврийн байгууллагад итгэмжлэл” олгох эрх бүхий төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагын талаар албан хүсэлтээр лавлагаа авч тодруулахад энэ төрлийн итгэмжлэл олгох үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн байгууллага байхгүй гэдгийг мэдэгдсэн.

“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ХХК